

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ

ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

Тавин долдугаар зүйл

1. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг оорчлох асуудлыг эдийн засгийн бүтэц, хvн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

Тавин наймдугаар зүйл

Дөрөвдүгээр бүлэг

Бичсэн Administrator

2010 оны 2-р сарын 05, Баасан гариг, 02:44 -

1. Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, оорийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мон.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын оргон мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

Тавин есдүгээр зүйл

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн оороо удирдах ёсыг торийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.

2. Нутгийн оороо удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Толоологчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чолоо цагт түүний Тэргүүлэгчид мон.

3. Аймаг, нийслэлийн Толоологчдийн Хурлыг дорвон жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн хурлын тоолологчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.

Жардугаар зүйл

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт торийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.

2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дорвон жилийн хугацаагаар томилно.

Дөрөвдүгээр бүлэг

Бичсэн Administrator

2010 оны 2-р сарын 05, Баасан гариг, 02:44 -

3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол омнох Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.

Жаран нэгдүгээр зүйл

1. Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг торийн толоологчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын омно хариуцна.

2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.

3. Тавьсан хоригийг нь Хурал оорийн толоологчдийн олонхийн саналаар няцаасан ноцолд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.

4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мон. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.

Жаран хоёрдугаар зүйл

1. Нутгийн оороо удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хvн амыг зохион байгуулж оролцуулна.

2. Нутгийн оороо удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны

Дөрөвдүгээр бүлэг

Бичсэн Administrator

2010 оны 2-р сарын 05, Баасан гариг, 02:44 -

байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, торийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн оороо удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд оорийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.

Жаран гуравдугаар зүйл

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана.

2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлогчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх богоод түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хвчин тоголдор дагаж мордоно.

3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.